

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
NATIONAL STATISTICAL OFFICE OF MONGOLIA

СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬ
MONTHLY BULLETIN OF STATISTICS



1 сар
2009
January

Улаанбаатар хот
Ulaanbaatar

ГАРЧИГ CONTENTS

Ерөнхий тэмдэглэл <i>General notes</i>	3
Аргачлалын тайлбар <i>Methodological notes</i>	4
Товч танилцуулга <i>Introduction</i>	7
Үндсэн үзүүлэлтүүд <i>Main indicators</i>	19
I. Улсын төсөв <i>State budget</i>	20
II. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл <i>Money, loan, stock market</i>	22
III. Үнэ <i>Price</i>	29
IV. Гадаад худалдаа <i>External trade</i>	40
V. Аж үйлдвэр <i>Industry</i>	50
VI. Хөдөлмөр <i>Labour</i>	55
VII. Хөдөө аж ахуй <i>Agriculture</i>	61
VIII. Тээвэр <i>Transport</i>	63
IX. Зоогийн газар, зочид буудал <i>Restaurant & Hotel</i>	64
X. Эрүүл мэнд <i>Health</i>	66
XI. Гэмт хэрэг <i>Crime</i>	69
XII. Цаг уур, агаарын бохирдолт <i>Meteorology and air pollution</i>	72
Хаврсалт <i>Appendix</i>	74

Ерөнхий тэмдэглэл

General notes

I. Товчилсон тэмдэглэгээ:

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГО	Говь-Алтай
ДО	Дорноговь
ДД	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
ДА	Дархан-Уул
УБ	Улаанбаатар
ОР	Орхон
ГС	Говьсүмбэр

I. Abbreviations:

AR	Arkhangai
BO	Bayan-Olgii
BKH	Bayankhongor
BU	Bulgan
GO	Govi-Altai
DO	Dornogovi
DD	Dornod
DU	Dundgovi
ZA	Zavkhan
OV	Ovorkhangai
OM	Omnogovi
SU	Sukhbaatar
SE	Selenge
TO	Tov
UV	Uvs
KHO	Khovd
KHS	Khovsgol
KHE	Khentii
DA	Darkhan-Uul
UB	Ulaanbaatar
OR	Orkhon
GS	Govisumber

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... г.м)

I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

1990-1995; 1990-1997 тухайн хугацааны жилийн дундаж үзүүлэлт болно.

III. Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:

- ... мэдээлэл байхгүй
- 0.0** маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй.

☐ “Үүнээс” гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

II. Months have been shown by the Roman numerals (I, II, III, IV, V, etc).

I-XII shows the accumulated data from the beginning of the year including the particular month.

1990-1995; 1990-1997 annual average for this particular time period.

III. The following symbols were used:

- ... data are not available
- 0.0** the amount is nil or negligible
- no execution.

☐ Shows the term “of which” and in some cases it indicates not all elements of sum are given.

IV. Due to the rounding figures (composition) may not add up to the total and 100 percentage.

Аргачлалын тайлбар**Methodological notes****Монгол Улсын нэгдсэн төсөв****General government budget**

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна.

Since October 1995, the budget revenue and expenditure has been compiled according to the International Monetary Fund standard classifications.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

The Mongolian General government budget revenue and expenditure consists of the central and local budget revenue and expenditure.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Сангийн яам аймаг, нийслэлийн харъяа нэгжүүдээсээ авч нэгтгэн Үндэсний Статистикийн хороо (ҮСХ)-нд ирүүлдэг.

The Ministry of Finance collects and aggregates the General government budget revenue and expenditure data from its department and offices that are under the jurisdiction of the ministry and forward the data to the National Statistical Office (NSO).

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын дүнд Засгийн газрын тусгай зориулалтын гэж нэрлэдэг Тэтгэврийн, Нийгмийн халамжийн, Замын, Өмч хувьчлалын сангуудын орлого, зарлагыг оруулсан.

State budget revenue and expenditure includes revenue and expenditure of Government Special funds for Pension, Social Security, Roads, and Privatization.

Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл**Money, loan, stock market**

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд банкнаас гадуурх мөнгө, банкны касс дахь бэлэн мөнгийг оруулна.

Currency in circulation includes the population and commercial banks cash and currency outside the banks.

Мөнгө М1-д улсын болон хувийн секторын харилцах дансан дахь мөнгө, иргэдийн хугацаагүй хадгаламж, банкны гадуурх бэлэн мөнгийг хамруулна.

Money M1 includes public and private sector's bank account currency, population demand deposits and currency outside the banks.

Мөнгө М2 бол Мөнгө М1 болон бараг мөнгөний нийлбэр юм. Бараг мөнгөнд иргэд, байгууллагуудын хугацаатай хадгаламжууд, гадаад валютын хадгаламжийг хамруулна.

Money M2 is a sum of money M1 and Quasi money. Quasi money consists of the time saving deposits of individuals and enterprises as well as foreign currency deposits.

Үнэт цаасны тухайн сарын арилжаанд хамгийн их гүйлгээтэй байсан компанийн хувьцааг идэвхтэй хувьцаа гэж үздэг.

An active stock in a particular month is considered as the stock of companies with predominated trading.

Үнэ**Prices**

Аймгийн төв, нийслэлийн захуудад борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

The average market prices of agricultural foodstuff, wool, hide & skin at aimags centers & the capital city were shown.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг

The consumer price index is a weighted average by consumption expenditure distribution of prices of various

хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2005 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

goods and services purchased by the households for its own consumption.

Since January 2008 having revised its methodology for CPI by which CPI for Ulaanbaatar city was taken a national CPI, the National Statistics Committee has moved to the international methodology by which the national CPI is estimated on the basis of weighted average for 2005 HIES consumption expenditure of aimags and the Capital city.

Гадаад худалдаа

Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын статистикийн мэдээг үндэслэн тус бүлгийн хүснэгтүүдийг боловсруулав.

Дэлхийн Худалдааны Байгууллагаас (шинэ нэрээр) боловсруулсан "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг авсан болно. С.И.Ф нөхцөлийн үнээр импортын барааг үнэлэх бөгөөд энэ нь худалдан авагч орны хил хүртэлх тээврийн болон даатгалын, гаалийн хураамж зэрэг зардлуудыг экспортлогч хариуцна гэсэн үг.

External trade

The tables of this chapter were developed on the basis of the statistical reports from the Customs General Administration of Mongolia.

The commodities were classified according to the Harmonized System developed by the World Trade Organization. The price of import goods is defined by the CIF condition which means that exporter has to bear costs of transportation & insurance till purchaser's country border as well as customs tax.

Аж үйлдвэр

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийг ҮСХ-ны даргын 2008 оны 132 тоот тушаалаар батлагдсан "Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индекс тооцох аргачлал"-ын дагуу тооцсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Industry

Classification by the kind of economic activities is based on the ISIC (International Standard Industrial Classification) of United Nation.

The value of total industrial sale is value of sales, completed work and services of business entities during the particular period.

Industrial index was calculated according to a Methodology for Calculation of Industrial Production Index approved by a decree 132 of 2008 issued by Chairman of NSO.

Data on production of the main industrial commodities shows a physical quantity of the particular produced goods.

Хөдөлмөр

Ажиллагчдын тоо нь сарын эцэст бэлэн байгаа тухайн салбарын ажиллагчдын тоо юм. Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орсон.

Эрүүл мэнд

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)-ыг 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Гэмт хэрэг

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нэлээд өөрчлөгдсөн.

-Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг нэгтгэн оруулсан.

-Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

-Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

-Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

-Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

Labour

The employment is the number of employees of the particular economic sector at the end of the month. According to the International standard methodology unemployed persons are those segments of the population in the working age who are currently not working in a paid or self-employed, actively looking for job and registered at the Employment Office.

Health

The infant mortality rate (infants under age one year per 1000 live births) is estimated as a ratio of the number of deaths of infants under 1 year to the number of alive births during a particular period of time.

Crime

The Crime indicators have been innovated and enriched in connection with change of Criminal Law.

- Indicators like crime against human life, health, crime to cause others to commit suicide, violent crime such as attempted and negligent murder are being compiled in the bulletin;

- Rape crime was included to the crime against children, family and social morality;

- Crime against ownership right includes theft of property, robbery, snatch away others property, deceiving to obtain others property, illegally misuse others property and wasting;

- Arson was included to crime against environmental protection.

- Indecent assault was added to crime against social safety.

The number of committed offences per 10000 population aged 18 and over is a quotient of the number of crimes and number of people aged 18 and over at the beginning of the year.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдал

(2009 оны 1 дүгээр сарын байдлаар)

Economic and Social Situation of Mongolia

(As January of 2009)

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2009 оны 1 дүгээр сарын байдлаар 83.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 112.5 тэрбум төгрөг болж, нийт тэнцэл 28.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 91.6 тэрбум төгрөгөөр, нийт зарлага, эргэж төлөгдөх төлөгдөх цэвэр зээлийн дүн 24.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

Төсвийн урсгал орлого 83.7 тэрбум төгрөг, урсгал зардал 102.4 тэрбум төгрөг болж, урсгал тэнцэл 18.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 44.4 хувь, үүний дотор гадаад худалдааны татварын орлого 16.2 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.5 хувиар тус тус буурав.

Татварын бус орлого 7.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 79.7 хувиар буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнд урсгал зардал 91.0 хувь, хөрөнгийн зардал 8.4 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 0.5 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс урсгал зардлын эзлэх хувийн жин 7.2 пунктээр буурсан боловч, хөрөнгийн зардлын эзлэх хувийн жин 6.9 пункт, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хувийн жин 0.3 пунктээр өссөн байна.

Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл

Монгол банкны мэдээгээр мөнгөний нийлүүлэлт (M2) 2009 оны 1 дүгээр сарын эцэст 2260.0 тэрбум төгрөгт хүрсэн нь 2008 оны 12 дугаар сарынхаас 58.9 тэрбум төгрөгөөр буюу 2.5 хувиар, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 57.3 тэрбум төгрөгөөр буюу 2.5 хувиар тус тус буурсан байна. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2009

General Government budget

In the January of 2009, total revenue and grants of General Government budget amounted to 83.8 bln.togrogs and total expenditure and net lending 112.5 bln.togrogs. The General government budget overall balance was a deficit 28.7 bln.togrogs.

Compared with the same period of previous year, total revenue and grants of General Government and total expenditure and net lending decreased by 91.6 bln.togrogs and 24.5 bln.togrogs, respectively.

Current revenue of General Government amounted to 83.7 bln.togrogs and current expenditure 102.4 bln.togrogs. The budget current balance was a deficit 18.7 bln.togrogs.

Compared with the same period of previous year, tax revenue decreased by 44.4 percent, of which taxes on foreign trade decreased by 16.2 percent and value added tax decreased by 3.5 percent, respectively.

Non-tax revenue reached 7.4 bln.togrogs, which decreased by 79.7 percent compared with the same period of previous year.

The share of current expenditure in the total expenditure and net lending amounted to 91.0 percent, which decreased by 7.2 points compared with the same period of the previous year. But shares of capital expenditure and net lending in the total expenditure and net lending amounted to 8.4 percent and 0.5 percent, which increased by 6.9 points and 0.3 points compared with the same period of the previous year, respectively.

Money, Loan and Stock market

According to the report of the Bank of Mongolia, at the end of January of 2009 money supply (broad money or M2) decreased by 58.9 bln.togrogs or 2.5 percent over the December of 2008, reaching 2260.0 bln. togrogs and decreased by 57.3 bln.togrogs or 2.5 percent compared to January of 2008. At the end of January, 2009

оны 1 дүгээр сарын эцэст 346.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2008 оны 12 дугаар сарынхаас 60.6 тэрбум төгрөгөөр буюу 14.9 хувь буурч, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 8.2 тэрбум төгрөгөөр буюу 2.4 хувиар нэмэгдлээ. Иргэд, байгууллагын төгрөгийн хадгаламж 2008 оны 12 дугаар сарынхаас 11.5 тэрбум төгрөгөөр буюу 1.2 хувиар, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 209.3 тэрбум төгрөгөөр буюу 18.5 хувиар тус тус буурч 922.6 тэрбум төгрөгт хүрэв. Гадаад валютын хадгаламж 493.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2008 оны 12 дугаар сарынхаас 53.4 тэрбум төгрөгөөр буюу 12.1 хувь өсч, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 113.1 тэрбум төгрөгөөр буюу 29.7 хувиар илүү байна.

2009 оны 1 дүгээр сарын эцэст аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеийнхээс 25.2 хувиар өсч, 2672.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеийнхээс 11.5 хувиар, хувийн байгууллагынх 37.9 хувиар, санхүүгийн бусад байгууллагынх 10.2 хувиар тус тус өссөн бол улсын байгууллагынх 26.4 хувиар, бусад байгууллагынх 14.1 хувиар тус тус буурчээ. Харин хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 79.2 тэрбум төгрөгөөр буюу 2.7 дахин, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 128.6 тэрбум төгрөгөөр буюу 2.9 дахин өсөв. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 196.2 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.3 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 4.2 пунктээр нэмэгдсэн байна.

Гадаад валютын цэвэр албан нөөц 2008 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 637.2 сая ам.долларт хүрсэн нь манай улсын импортын 9.2 долоо хоног буюу 2.3 сарын хэрэгцээг хангахуйц түвшинд хүрсэн байна. 2007 оны мөн үеийнхтэй харьцуулахад гадаад валютын цэвэр албан нөөц 335.2 сая ам.доллар буюу 34.5 хувиар буурсан байна.

Төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханш 2009 оны 1 дүгээр сарын эцэст 1381.66 төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 17.9 хувь, 2008 оны 12 дугаар сарынхаас 9.0 хувь тус тус суларчээ. Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн ханш 1807.63 төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 4.4 хувь,

currency issued in circulation decreased by 60.6 bln.togrogs or 14.9 percent compared to December of 2008, reaching 346.6 bln.togrogs and increased by 8.2 bln.togrogs or 2.4 percent compared to January of 2008. Domestic currency deposits decreased by 11.5 bln.togrogs or 1.2 percent over the December of 2008, decreased by 209.3 bln.togrogs or 18.5 percent compared to January of 2008, reaching 922.6 bln.togrogs. As for foreign currency deposits increased by 53.4 bln.togrogs or 12.1 percent reaching 493.6 bln.togrogs over the December of 2008 and increased by 113.1 bln.togrogs 29.7 percent compared to January of 2008.

At the end of January 2009 the remainder of loans outstanding increased by 25.2 percent compared to January of 2008, reaching 2672.0 bln.togrogs. Loans for individuals are increased by 11.5 percent, private sectors increased by 37.9 percent and other financial corporations increased by 10.2 percent, respectively. Public sectors decreased by 26.4 percent, other sectors decreased by 14.1 percent, respectively. Meanwhile, principals in arrears increased by 79.2 bln.togrogs or 2.7 times and substandard, doubtful, loss loans increased by 128.6 bln.togrogs or 2.9 times. The non-performing loans reached 196.2 bln.togrogs, which was 7.3 percent of the total loans outstanding is increased by 4.2 point compared with January of 2008.

At the end of December of 2008, the reverse assets reached to 637.2 mln US.dollars which equals with the import needs of 9.2 weeks or 2.3 months. Compared with the December of 2007, the reverse assets decreased by 335.2 mln.US dollars or 34.5 percent.

Mongolbank's the nominal rate of togrog against US.dollar is 1381.66 togrog at the end of January 2009. Compared with January of 2008, rate of togrog weaken by 17.9 percent. Compared with December of 2008, rate of togrog weaken by 9.0 percent. The nominal rate of togrog against EUR is 1807.63 togrog at the end of January 2009.

2008 оны 12 дугаар сарынхаас 1.2 хувь тус тус сулрав. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 202.01 төгрөг болж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 24.0 хувь, 2008 оны 12 дугаар сарынхаас 9.0 хувь тус тус суларсан байна.

Хөрөнгийн биржид үнэт цаасны арилжаа 2009 оны 1 дүгээр сард 21 удаа явагдаж, 2.4 сая ширхэг үнэт цаас арилжигдаж, 472.6 сая төгрөгийн гүйлгээ хийгдэв. Арилжигдсан үнэт цаасны тоо 2008 оны 12 дугаар сарынхтай харьцуулбал 1.9 хувиар өсч, гүйлгээний хэмжээ нь 36.2 хувиар буурсан байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад арилжигдсан үнэт цаасны тоо 78.9 хувиар, гүйлгээний хэмжээ 86.7 хувиар тус тус буурсан байна.

ТОП-20 дундаж индекс 2009 оны 1 дүгээр сард 5318.5 болж, өмнөх сарынхаас 459.2 нэгжээр буурчээ. Хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаний нийт үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2009 оны 1 дүгээр сард 450.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сарынхаас 65.6 тэрбум төгрөгөөр буюу 12.7 хувиар буурсан байна.

Compared with January of 2008, rate of togrog weaken by 4.4 percent. Compared with December of 2008, rate of togrog weaken by 1.2 percent. The nominal rate of togrog against CNY is 202.01 togrog at the end of January 2009. Compared with January of 2008, rate of togrog weaken by 24.0 percent. Compared with December of 2008, rate of togrog weaken by 9.0 percent. According to Mongolian Stock Exchange report, in January of 2009, the stocks were traded 21 times, in total 2.4 mln. stocks were traded and value of traded stocks has reached to 472.6 mln. togrogs. Compared with December of 2008, stocks traded increased by 1.9 percent and value of traded stocks decreased by 36.2 percent. Stocks traded decreased by 78.9 percent and value of traded stocks decreased by 86.7 percent compared with January of 2008.

During the January of 2009, the TOP-20 average index decreased by 459.2 points compared with December of 2008, reaching 5318.5 point. Total market capitalization of listed companies decreased by 65.6 bln. togrogs or 12.7 percent compared with December of 2008, reaching 450.3 bln. togrogs in January of 2009.

Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн улсын индекс(ХҮИ) 2009 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 0.8 хувь, өмнөх оны 1 дүгээр сарынхтай харьцуулахад 20.7 хувь өссөн байна.

Боловсролын үйлчилгээний болон шуудан, холбооны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ тогтвортой, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 0.8 хувь, тээврийнх 1.9 хувь буурсан бөгөөд тэдгээрээс бусад бүлгийн үнэ дүнгээрээ 0.2-7.3 хувь өсчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тариф 2009 оны 1 дүгээр сард өмнөх сартай харьцуулахад Увс, Говьсүмбэр, Баян-Өлгий аймагт 0.5-1.6 хувь буурч, нийслэл болон бусад аймагт 0.1-3.8 хувиар өслөө.

Consumer price index

In January 2009, the national consumer price index increased by 0.8 percent compared with previous month, by 20.7 percent from January of previous year.

The prices of education and communication groups were stable but the prices of housing, water, electricity and fuels decreased by 0.8 percent and transportation by 1.9 percent. The prices of other groups excluding above mentioned went up by 0.2-7.3 percent.

In January 2009, the consumer price index decreased by 0.5-1.6 percent in Uvs, Govisumber and Bayan-OLgii aimags and in the rest aimag and in the Capital city consumer prices increased by 0.1-3.8 percent compared with previous month.

Барилгын гол нэрийн материалын Улаанбаатар хотын дундаж үнэ

Улаанбаатар хотод арилжаалагдаж байгаа эх орны үйлдвэрийн болон ОХУ,

Average prices of major construction materials on sale in Ulaanbaatar

In the January 2009 report of average prices of major construction materials on sale

БНХАУ, ХБНГУ, БНСУ-д үйлдвэрлэсэн 36 нэр төрлийн барилгын материалын үнийг 2009 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар мэдээнд хамрууллаа. Эдгээр нэр төрлийн барилгын материалын үнийг 2008 оны 12 дугаар сарынхтай харьцуулахад эх орны үйлдвэрийн палкны үнэ 6.7 хувь, захалсан банзны үнэ 40.0 хувь, БНХАУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 7.1 хувь, хар цаасны үнэ 16.7 хувь, 30x30 хэмжээтэй плитаны үнэ 16.7 хувиар буурч, бусад нэр төрлийн материалын хувьд үнэ тогтвортой байлаа.

Барилгын материалын үнийн өсөлт, бууралтын хандлагыг 2008 оны 1 дүгээр сараас хойш хугацаанд авч үзвэл 21 нэр төрлийн материалын үнэ өсч, вакуум цонхны үнэ буурч, бусад 14 нэр төрлийн материалын хувьд харьцангуй тогтвортой байв.

Эх орны үйлдвэрийн хөнгөн бетоны үнэ 2008 оны 1 дүгээр сарынхаас 6.3 хувь, захалсан банзных 15.4 хувь, улаан тоосгоных 66.7 хувь, шалны ховилгүй банзных 71.4 хувь, палкных 2 дахин нэмэгдсэн байна.

ОХУ-аас импортоор авдаг хадаасны үнэ 2008 оны 1 дүгээр сарынхаас 11.1, хар цаасны үнэ 21.7 хувиар тус тус өсчээ.

БНХАУ-аас импортоор авдаг чулуугүй хар цаасны үнэ 2008 оны 1 дүгээр сарынхаас 11.1 хувь, 30x30 хэмжээтэй плитаных 11.1 хувь, дүүжин таазных 12.0 хувь, паркетан шалных 13.3 хувь, хадаасных 20.0 хувь, шаазан угаагуурных 20.0 хувь, шаазан суултуурных 20.0 хувь, өдрийн гэрэлнийх 20.0 хувь, тосон будагных 25.0 хувь, ханын цаасных 30.0 хувь, цонхны нөлөөгүй шилнийх 41.2 хувь, цонхны нөлөөтэй шилнийх 53.8 хувиар тус тус өссөн байна.

Орон сууцны үнийн индекс

Нийслэлийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2008 оны 4 дүгээр улиралд өмнөх оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 18.3 хувь өсч, харин 2008 оны 1 дүгээр улирлынхаас 5.7 хувь, 2 дугаар улирлынхаас 16.2 хувь, 3 дугаар улирлынхаас 16.4 хувь тус тус буурсан байна.

in Ulaanbaatar which are produced by Mongolia, Russian Federation, People's Republic of China, Federal Republic of Germany and Republic of Korea 36 are covered. At the end of January price of palk made in Mongolia decreased by 6.7 percent, edged plank decreased by 40.0 percent, wallpaper made in China decreased by 7.1 percent, roofing paper decreased by 16.7 percent, slabstone /30x30/ decreased by 16.7 percent compared to the previous month and for remaining materials prices were stable.

Compared to the same period of 2008, prices of 21 types of construction materials were increased, price of vacuum window was decreased and for other 14 types of construction materials prices were stable.

Compared to the same period of 2008, price of iron concrete increased by 6.3 percent, edged plank increased by 15.4 percent, brick increased by 66.7 percent, plank for floor without groove increased by 71.4 percent, palk increased by 2 times.

At the end of January 2009, price of imported from Russian Federation's spike increased by 11.1 percent, price of roofing paper increased by 21.7 percent compared to the same period of the previous year.

At the end of January 2009, prices of imported from People's Republic of China's roofing paper without stone increased by 11.1 percent, slabstone /30x30/ increased by 11.1 percent, false ceiling increased by 12.0 percent, parquet floor increased by 13.3 percent, spike increased by 20.0 percent, ceramic sink increased by 20.0 percent, ceramic lavatory pan increased by 20.0 percent, electric filament lamp increased by 20.0 percent, oil paint 25.0 percent, wallpaper increased by 30.0 percent, without reflection window glass increased by 41.2 percent, with reflection window glass increased by 53.8 percent compared to the same period of 2008.

Housing price index

In the 4th quarter of 2008, price of apartment increased by 18.3% in 6 districts of the Capital city compared to 4th quarter of previous year. But it decreased by 5.7% compared to 1st quarter, 16% compared 2nd quarter and 16.4% compared to 3rd quarter of 2008.

Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд орон сууцны үнэ 2008 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 5.5-50.7 хувиар өссөн бол, 2008 оны 3 дугаар улирлынхтай харьцуулахад 10.9-18.8 хувиар буурсан нь судалгаагаар тогтоогдлоо.

In 4th quarter of 2008, price of apartment increased by 5.5-50.7% in 6 districts of the Capital city compared to the end of 2007. But it decreased by 10.9-18.8% compared to 3rd quarter of 2008.

Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2009 оны 1 дүгээр сарын байдлаар 298.0 сая ам.доллар, үүнээс экспорт 170.4 сая, импорт 127.6 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 42.7 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеийнхээс 40.9 сая ам.доллараар, 2008 оны 12 дугаар сарынхаас 106.2 сая ам.доллараар тус тус илүү байна. Гадаад худалдааны тэнцэл хэдийгээр ашигтай гарсан ч нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеийнхээс 30.9 хувь, экспорт 21.3 хувь, импорт 40.6 хувиар тус тус буурав.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүн 60.5 сая ам.доллараар; түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл 3.4 сая ам.доллараар буурч, харин үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлс 12.8 сая ам.доллараар; мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн 0.6 сая ам.доллараар; хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 0.2 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн байна.

Нийт экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 46.1 сая ам.доллараар буюу 21.3 хувиар буурсны 42.2 сая ам.доллар буюу 91.4 хувь нь үнийн бууралт, харин 3.9 сая ам.доллар буюу 8.6 хувь нь биет хэмжээний бууралт байна.

Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 7.0 хувиар, үнийн дүн нь 55.3 хувиар тус тус буурсан байна. 2008 оны 1 дүгээр сарын байдлаар нэг тонн зэсийн баяжмалын үнэ дунджаар 1280.0 ам.доллар байсан бол 2009 оны 1 дүгээр сард 615.2 ам.доллар болж, 664.8 ам.доллараар буюу 51.9 хувиар буурлаа. Цайрын баяжмалын экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 69.4 хувиар, үнийн дүн нь 86.8

External trade

For the first month of 2009, total external trade turnover equaled 298.0 mln.US dollars, of which exports 170.4 mln.US dollars and imports 127.6 mln.US dollars. Total external trade balance turned a surplus of 42.7 mln.US dollars. The surplus is increased by 40.9 mln.US dollars compared with the same period of the previous year, increased by 106.2 mln.US dollars compared with the December of the previous year. Although the total external trade balance turned a surplus, but the total external trade turnover was decreased by 30.9 percent, exports by 21.3 percent and imports by 40.6 percent respectively.

As compared with the same period of the previous year, mineral products exports, which are comprised high percentage in the exports, decreased by 60.5 mln.US dollars, raw and processed hides, skins, fur and articles thereof exports decreased by 3.4 mln.US.dollars; but natural or cultured stones, precious metal, jewellery exports increased by 12.8 mln.US.dollars, live animals, animals origin products increased by 0.6 mln.US dollars, chemical and chemical industry products increased by 0.2 mln.US dollars respectively.

As compared with the same period of the previous year, total export decreased by 21.3 percent or 46.1 mln.US dollars, of which 91.4 percent or 42.2 mln. US dollars due to price decrease, 8.6 percent or 3.9 mln. US dollars due to volume decrease.

The volume of copper concentrate exports decreased by 7.0 percent, their value in US dollars decreased by 55.3 percent compared with the same period of the previous year. For the first month of 2008, the average price of copper concentrate per ton was 1280.0 US dollars. But in the first month of 2009, it was 615.2 US dollars and decreased by 664.8 US dollars or 51.9 percent. The volume of zinc concentrate exports decreased by 69.4 percent, their value in US dollars decreased by 86.8

хувиар тус тус буурсан байна. 2008 оны 1 дүгээр сарын байдлаар нэг тонн цайрын баяжмалын үнэ дунджаар 1266.9 ам.доллар байсан бол 2009 оны 1 дүгээр сард 546.0 ам.доллар болж, 721.0 ам.доллараар буюу 56.9 хувиар буурав.

Боловсруулаагүй алтны экспортын биет хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад биет хэмжээ нь 10.4 хувиар, үнийн дүн нь 13.6 хувиар өссөн байна. 2008 оны 1 дүгээр сард нэг кг боловсруулаагүй алтны үнэ дунджаар 26.8 мянган ам.доллар байсан бол 2009 оны 1 дүгээр сард 27.6 мянган ам.доллар болж, 773.1 ам.доллараар буюу 2.9 хувиар нэмэгдэв.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний импорт 39.1 сая ам.доллараар; авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 16.3 сая ам.доллараар; ургамлын гаралтай бүтээгдэхүүний импорт 9.6 сая ам.доллараар; үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн 6.1 сая ам.доллараар; нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт 1.7 сая ам.доллараар; хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 1.0 сая ам.доллараар тус тус буурч, харин машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийн импорт 0.9 сая ам.доллараар өссөн байна.

Нийт импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 87.1 сая ам.доллараар буюу 40.6 хувиар буурсан. Үүнд импортын бүтээгдэхүүний тоо хэмжээ багассанаас импорт 97.6 сая ам.доллараар буурч, үнийн өсөлтөөс 10.5 сая ам.доллараар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үеийнхээс автобензиний импортын биет хэмжээ 16.1 мянган тонноор, үнийн дүн нь 17.7 сая ам.доллараар; гурилын импортын биет хэмжээ 17.1 мянган тонноор, үнийн дүн 6.8 сая ам.доллараар; цахилгаан эрчим хүчний импортын биет хэмжээ 14.4 сая квт.цагаар, үнийн дүн 516.9 мянган ам.доллараар тус тус буурч; харин суудлын автомашины импортын биет хэмжээ 0.6 мянган ширхэгээр буурсан байхад үнийн дүн 246.2 мянган ам.доллараар өслөө.

percent compared with the same period of the previous year .For the first month of 2008, the average price of zinc concentrate per ton was 1266.9 US dollars. But in the first month of 2009, it was 546.0 US dollars and decreased by 721.0 US dollars or 56.9 percent.

The volume of gold, unwrought or in semi-manufactured forms exports increased by 10.4 percent and their value in US dollars increased by 13.6 percent compared with the same period of the previous year. For the first month of 2008, the average price of gold, unwrought or in semi-manufactured forms per kilogram was 26.8 thous.US dollars. But in the first month of 2009, it was 27.6 thous.US dollars and increased by 773.1 US dollars or 2.9 percent.

As compared with the same period of the previous year, mineral products imports, which are comprised high percentage in the imports, decreased by 39.1 mln.US dollars, auto, air and water transport vehicles and their spare parts imports decreased by 16.3 mln.US dollars, vegetable origin products imports decreased by 9.6 mln.US dollars, base metals & articles thereof decreased by 6.1 mln.US dollars, textiles, textile articles and food products imports decreased by 1.7 mln.US dollars, chemical & chemical industry products decreased by 1.0 mln.US dollars, but machinery, equipment electric appliances, recorders, TV sets & spare parts imports increased by 0.9 mln.US dollars respectively.

As compared with the same period of the previous year, total import decreased by 40.6 percent or 87.1 mln.US dollars, of which 97.6 mln. US dollars due to volume decrease, 10.5 mln. US dollars due to value increase.

As compared with the same period of the previous year, petrol's imports decreased by 16.1 thous.tons or 17.7 mln.US dollars; flour imports decreased by 17.1 thous.tons or 6.8 mln.US dollars, electricity imports decreased by 14.4 mln.kwt.hours or 516.9 thous.US dollars; but car imports decreased by 0.6 thous.pieces and their value increased 246.2 mln.US dollars respectively.

Аж үйлдвэр**Industry**

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2009 оны 1 дүгээр сарын байдлаар оны үнээр 165.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 21.1 тэрбум төгрөгөөр буюу 11.3 хувиар буурлаа.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс 2009 оны 1 дүгээр сард 90.8 болж өмнөх сарынхаас 9.2 хувиар буурлаа.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийг дэд салбараар авч үзвэл ус ариутгал, усан хангамж; цахилгаан, дулаан, уур; нэхмэл болон хувцас, үслэг арьс боловсруулалт зэрэг 6 дэд салбарын үйлдвэрлэл өмнөх сарынхаас 0.9-53.2 хувь, тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл 3.2 дахин өсчээ. Харин цахилгаан машин хэрэгсэл; нүүрс; газрын тос; металлын хүдэр олборлолт зэрэг 10 дэд салбарт үйлдвэрлэл өмнөх сарынхаас 3.9-61.8 хувиар буурсан бол машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл 95.7 хувийн бууралттай байна.

Аж үйлдвэрийн мэдээнд хамрагдсан гол нэрийн бүтээгдэхүүнийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 54.1 хувийнх нь үйлдвэрлэл өсч, 45.9 хувийнх нь үйлдвэрлэл буурчээ.

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс цахилгаан, дулаан, нүүрс, 35 хувийн агуулгад шилжүүлсэн зэсийн баяжмал, 47 хувийн агуулгад шилжүүлсэн молибдений баяжмал, малын мах, шингэн сүү, хиамны зүйл, өлөн гэдэс, талх, гоймон, спирт, архи, пиво, цэвэр ус, жүүс, тамхи, хивс, шахмал эм, шохой, ган төмөр хийц, лаа зэрэг 92 бүтээгдэхүүний үйлдвэрлэл биет хэмжээгээр өсч, харин түгээсэн цэвэр ус, газрын тос, алт, хайлуур жоншны баяжмал, цайрын баяжмал, гурил, тараг, нарийн боов, чихэр, дарс, катодын зэс, төмөр бетон эдлэл, шавардлагын зуурмаг, хөөсөнцөр хавтан, металл бэлдэц, металл цувимал, нэг удаагийн тариур зэрэг 78 бүтээгдэхүүний үйлдвэрлэл биет хэмжээгээр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2009 оны 1 дүгээр сард 156.9 тэрбум төгрөгийн (оны үнээр) бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулав.

In the January of 2009, the total industrial output was 165.5 bln.togrogs at current prices, that was more than by 11.3 percent or 21.1 bln.togrogs with the same period of previous year.

At the end of January 2009, industrial production index was 90.8 percent, 9.2 percent decrease from the previous month.

By the subsectors of total output of industry, 6 subsectors, collection, purification and distribution of water; electricity, thermal energy, steam; textiles and wearing apparel, dressing and dyeing of fur etc increased by 0.9-53.2 percents compared with previous month and manufacture of other transport equipment increased by 3.2 times. But 10 subsectors, manufacture of electrical machinery and apparatus; mining of coal, extraction of crude petroleum and natural gas; mining of metal ores etc decreased by 3.9-61.8 and other manufacture of fabricated metal products, machinery and equipment decreased by 95.7 percent compared with previous month.

Compared with the same period of previous year, the production of 54.1.% of main industrial products increased, while the remaining 45.9% decreased.

Production of main items of industrial products, electricity, thermal energy, coal, copper concentrate with 35%, molybdenum concentrate with, 47%, meat, milk, sausage, small intestine, bread, macaroni noodles, spirit, alcoholic beverages, beer, pure water, juice, cigarettes, carpet, medical tablets, lime, steel casting, candle etc. 92 products increased by volume; distribution of water, crude oil, gold, fluor, spar concentrate, zincum concentrate, flour, sour milk and yoghurt, bakery products, sweets, wine, copper, articles of iron concrete, plastering mortar, lather panel, metal steel, metal foundries, disposable injection etc. 78 products decreased by volume.

For the January of 2009, production of industry (at current prices) on 156.9 bln.togrogs sold at domestic and foreign markets. As at January of 2009, products manufactured in Industrial sector amounting 156.9 million MNT (at current prices) sold at domestic and foreign markets.

Хөдөө аж ахуй

Улсын хэмжээгээр 2009 оны 1 дүгээр сарын байдлаар 120.4 мянган том мал, үүний дотор 67.3 мянган ямаа, 41.4 мянган хонь, 7.7 мянган үхэр, 3.9 мянган адуу, 0.1 мянган тэмээ зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс нийт дүнгээр 70.7 мянгаар илүү байна.

Нийт хорогдлын 80.8 хувь нь Завхан (19.6%), Баян-Өлгий (18.6%), Увс (16.5%), Ховд (12.0%), Баянхонгор (7.3%) болон Говь-Алтай (6.8%) аймагт ногдож байна.

Тээвэр

Төмөр замын тээврээр 2009 оны 1 дүгээр сард 1044.3 мянган тонн ачаа, давхардсан тоогоор 247.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 283.2 мянган тонн буюу 21.3 хувь, зорчигчдын тоо 100.2 мянган хүн буюу 28.8 хувиар тус тус буурлаа. Төмөр замын дотоодод тээвэрлэсэн ачаа 63.3 мянган тонн буюу 8.5 хувь, олон улсад тээвэрлэсэн ачаа 219.9 мянган тонн буюу 37.9 хувиар буурав. Дамжин өнгөрөх тээврийн ачааны хэмжээ 142.1 мянган тонн болж, өмнөх оны мөн үеийнхээс 94.6 мянган тонн буюу 40.0 хувиар буурсан байна.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2009 оны 1 дүгээр сард 11.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 6.2 тэрбум төгрөг буюу 35.8 хувиар буурчээ.

Агаарын тээврээр 2009 оны 1 дүгээр сард 106.2 тонн ачаа, давхардсан тоогоор 18.2 мянган зорчигч тээвэрлэж, өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 19.3 тонн буюу 15.4 хувь, зорчигчдын тоо 4.9 мянган хүн буюу 20.9 хувиар тус тус буурлаа. Агаарын тээврээр олон улсад тээвэрлэсэн зорчигчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 1.9 мянган хүн буюу 11.4 хувь, дотоодод тээвэрлэсэн зорчигчдын тоо 3.0 мянган хүн буюу 45.9 хувиар буурав.

Агаарын тээврийн салбарын орлого 2009 оны 1 дүгээр сард 4.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 459.9 сая төгрөг буюу 8.9 хувиар буурчээ.

Agriculture

In the January of 2009, 120.4 thous.adult animals have been lost, of which 67.3 thous.goat, 41.4 thous.sheeps, 7.7 thous.cattle, 3.9 thous.horse and 0.1 thous.camel. It increased by 70.7 thous.head compared with the same period of previous year.

80.8 percent of the total losses accounted in Zavkhan (19.6%), Bayan-Olgii (18.6%), Uvs (16.5%), Khovd (12.0%), Bayankhongor (7.3%) and Govi-Altai (6.8%) aimags.

Transport

In January of 2009, 1044.3 thous.ton of freight and 247.2 thous.passengers (duplicated) were carried by railway transport. Compared with the same period of the previous year, the carried freight and carried passengers decreased by 21.3 percent or 283.2 thous.ton and by 28.8 percent or 100.2 thous.persons. The railway transportation domestic carried freight and international carried freight were decreased by 8.5 percent or 63.3 thous.ton and by 37.9 percent or 219.9 thous.ton, compared with the same period of the previous year. The carried transit freight reached to 142.1 thous.ton which decreased by 40.0 percent or 94.6 thous.ton, compared with the same period of the previous year.

In January of 2009, total revenue of railway transportation reached 11.1 bln.togrogs which decreased by 35.8 percent or 6.2 bln.togrogs compared with the same period of the previous year.

In January of 2009, 106.2 ton of freight and 18.2 thous.passengers (duplicated) were carried by air transport. Compared with the same period of the previous year, the carried freight and carried passengers decreased by 15.4 percent or 19.3 ton and by 20.9 percent or 4.9 thous.persons. For the air-transportation, the international and domestic carried passengers were decreased by 11.4 percent or 1.9 thous.persons and by 45.9 percent or 3.0 thous.persons, compared with the same period of the previous year.

In January of 2009, total revenue of air transportation reached 4.7 bln.togrogs which decreased by 8.9 percent or 459.9 mln.togrogs compared with the same period of the previous year.

Нийтийн хоол, зочид буудал

Нийтийн хоол, зочид буудлын салбарын нийт орлого 2008 онд 54.2 тэрбум төгрөгт хүрсний 32.4 тэрбум буюу 59.8 хувь нь зочид буудлын салбарт ногдож байна.

Зочид буудлын салбарын нийт орлогын 62.5 хувийг 3 болон түүнээс дээш одтой буудал, 35.2 хувийг энгийн болон 1 одтой буудал, 2.3 хувийг 2 одтой буудал тус тус эзэлж байна.

Зочид буудлын нэг өрөөнд ногдох дундаж орлого 2008 онд энгийн болон 1 одтой буудлын хувьд 3198.5 мянган төгрөг, 2 одтой буудлын хувьд 3650.0 мянган төгрөг, 3 ба түүнээс дээш одтой буудлын хувьд 17563.9 мянган төгрөг байна.

Нэг зочид буудалд 2008 онд дунджаар 1596 зочин байрлаж, нэг зочин дунджаар 1.4 хоног байрласан байна. Түүнчлэн нэг зочинд ногдох орлого дунджаар 67.7 мянган төгрөг болжээ.

Нийтийн хоолны салбарын нийт орлогын 54.1 хувийг ресторан, 23.5 хувийг кафе, 13.1 хувийг гуанз, цайны газрууд, 9.4 хувийг баарны орлого тус тус эзэлж байна.

Ажилгүйчүүд

Аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (ХХҮХ)-т бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2009 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар 31.4 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 5.6 хувь буюу 1.7 мянган хүнээр нэмэгдсэн байна.

Улсын хэмжээгээр 18.2 мянган эмэгтэй ажилгүй гэж бүртгүүлсэн нь нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 57.9 хувийг эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдээс 2009 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар 1.8 мян.хүн ажилд орсны 17.2 хувь нь төрийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагад, 82.8 хувь нь компани, хоршоо, бусад байгууллагад ажилд оржээ.

ХХҮХ-ийн мэдээгээр 2009 оны 1 сарын эцсийн байдлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гаас банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан 272 албан бус хөдөлмөр эрхлэгч, 438 ажилгүй иргэн, 184 малчин, 30 аж ахуйн нэгж, байгууллагад 1.3 тэрбум төгрөгийн зээл олгосноор 1918 хүн ажлын байраар хангагдсан байна.

Hotel and restaurant

In 2008, the total income of hotels and restaurants sector was 54.2 bln.togrogs, of which income from hotel sub sector was 59.8 percent or 32.4 bln. togrogs.

The total income of hotels comprises 62.5 percent of 3 and more stars hotel, 35.2 percent of motel and 1 star hotel and 2.3 percent of 2 stars hotel.

In 2008, the average income of motel and 1 star hotel room was 3198.5 thous.togrogs, for 2 stars hotel 3650.0 thous.togrogs, for 3 and more stars hotels 17563.9 thous.togrogs.

In 2008, in average 1596 persons stayed in hotel and 1 person stayed about 1.4 nights. Average spending of a person was 67.7 thous.togrogs.

The total income of restaurants comprises 54.1 percent of restaurant, 23.5 percent of cafe, 13.1 percent of canteen and 9.4 percent of bar.

Unemployment

At the end of January 2009, the number of registered unemployed was 31.4 thous, that increased by 5.6 percent or 1.7 thous. persons compared to the same period of the previous year.

The number of unemployed women was 18.2 thous, which is 57.9 percent of total registered unemployed.

At the end of January 2009, 1.8 thous. registered unemployed persons entered into work. Of whom 17.2 percent entered in government or state-owned enterprises and remaining 82.8 percent in companies, cooperatives or other types of employers, such as small-scale private businesses.

As a 1 January of 2009, "Employment support fund" has granted 1.3 bln.togrog loans for 272 self-employees, 438 unemployed persons, 184 herders and 30 establishments through the banks and non-banking financial institutions. As its results, 1918 persons have found working places.

Эрүүл мэнд

Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 2009 оны 1 дүгээр сард 5398 болж, өмнөх оны мөн үеийнхээс 281 хүүхдээр буюу 5.5 хувь, амаржсан эх 5379 болж, 289 эхээр буюу 5.7 хувиар тус тус нэмэгдэв.

Улсын хэмжээгээр нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 119 болж, өмнөх оны мөн үеийнхээс 23 хүүхдээр, эхийн эндэгдэл 4 болж, 3 эхээр тус тус нэмэгдэж, харин 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 18 болж, 4 хүүхдээр буюу 18.2 хувиар буурчээ.

2009 оны 1 дүгээр сард 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 25 болж өмнөх оны мөн үеийнхээс 2 пунктээр, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 22 болж өмнөх оны мөн үеийнхээс 3 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд ногдох/ Өмнөговь, Хэнтий, Баянхонгор, Сүхбаатар, Говьсүмбэр, Өвөрхангай, Увс, Дундговь аймаг, Улаанбаатар хотод улсын дунджаас дээгүүр байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 3.0 мянга байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 890 хүнээр буюу 23.1 хувиар буурав. Цусан суулгаар өвчлөгчдийн тоо өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 84.3 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 37.8 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 37.4 хувиар тус тус өсч, харин вируст гепатитаар өвчлөгчдийн тоо 56.1 хувь, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 41.3 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 19.2 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 0.8 хувиар тус тус буурсан байна.

ХДХВ/ДОХ-ын 1 тохиолдол 2009 оны 1 дүгээр сард гарч улсын хэмжээнд нийт ХДХВ/ДОХ-ын 50 тохиолдол бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2009 оны 1 дүгээр сард нийт 1.3 мянган хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 4.2 хувиар нэмэгдэж, үүнээс 25.7 хувь нь эмнэлэгт нас баржээ.

Эмнэлэгт нийт 53.2 мянган хүн хэвтэж эмчлүүлжээ. Хувийн эмнэлгүүд 2009 оны 1 дүгээр сард 51.2 мянган хүнд үйлчилж, 282.0 сая төгрөгийн төлбөртэй

Health

The number of births (live) in the January of 2009 reached 5398. This shows an increase of 5.5 percent or 281 children. The number of mothers delivered child was 5379 showing an increase of 5.7 percent or 289 mothers compared to the January of 2008.

In the meantime the number of infant mortality under the age of 1 stood at 119 hence showing a increases of 23 infant mortality and number of maternal deaths 4 showing an increase of 3 mothers compared to the January of 2008 respectively. There was a decrease in child mortality aged 1-5 reaching 18 which is by 18.2 percent or 4 children.

In the January of 2009, the under five mortality per 1000 live births was 25 showing an increase 2 point and infant mortality per 1000 live births was 22 showing 3 point compared to the January of 2008. The infant mortality rate under the age of 1 per 1000 live births was higher than the national average in Umnugovi, Khentii, Bayankhongor, Sukhbaatar, Govisumber, Uvurkhangai, Uvs, Dundgovi aimags and Ulaanbaatar city.

The number of infectious diseases was 3.0 thous. showing a decrease of 23.1 percent or 890 infectious compared to the January of 2008. The number of persons infected by shigellosis an increased by 84.3 percent, gonococcal infection by 37.8 percent, syphilis by 37.4 percent. The number of persons infected by viral hepatitis declined by 56.1percent, varicella by 41.3 percent, tuberculosis by 19.2 percent and trichomoniasis by 0.8 percent, respectively.

HIV/AIDS of 1 cases registered in this January of 2009 and now in national level have of 50 cases on HIV/AIDS.

In the January of 2009, total number of deaths were 1.3 thous. persons showing increases by 4.2 percent and compared to the January of 2008 25.7 percent of total deaths was registered in the hospital.

Total 53.2 thous. persons took treatment in the hospital. The private hospitals has been served 51.2 thous. persons and 282.0 mln.tugrug service. The number of persons served as hospital a increased by 3.7 percent and payment of

үйлчилгээ үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүний тоо 3.7 хувиар нэмэгдэж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ 28.2 хувиар буурсан байна.

service decreased by 28.2 percent compared to the January of 2008.

Гэмт хэрэг

